

БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Засгийн газраас эрх зүйн шинэтгэл хийх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээлэх, сурталчлах талаар олон арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, Засгийн газрын 1993 оны “Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг сайжруулах тухай” 57 дугаар тогтоолоор нийтийг хамарсан эрх зүйн сургалт зохион байгуулах, албан болон албан бус сургалт, мэдээллийн хэрэгсэл ашиглан хууль тогтоомжийг сурталчлах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх зэрэг олон асуудлыг зохицуулсан бол 1996 онд батлагдсан Засгийн газрын “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай” 66 дугаар тогтоолоор хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээлэх, нийтэд сурталчлахтай холбогдсон үүргийг төрийн албан хаагч бүрийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт тодорхой тусган биелэлтийн байдлыг улирал бүр дүгнэж ажиллахыг төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны удирдлагад даалгасан байна.

“Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”¹-т “Бүх нийтийн эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэх, иргэдэд улс төрийн болон эрх зүйн соёлыг эзэмшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төрийн бүх шатны байгууллагаас явуулна. Үндсэн хуулийн зарчим, үзэл санааг иргэн бүр чанд хэрэгжүүлэх үзлийг бага наснаас нь төлөвшүүлэхийг гол зорилго болгон, эрх зүйн сурталчилгаа, мэдээлэл, сургалтыг Үндсэн хууль, бусад хуулийг тууштай биелүүлэхэд чиглүүлнэ” гэж заасан. Түүнчлэн “Эрх зүйн албан бус сургалтын хөтөлбөр”², “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”³, “Эрх зүйн сурталчилгааны дунд хугацааны хөтөлбөр”⁴, “Эрх зүйн сурталчилгааг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”⁵, “Сум, дүүрэгт эрх зүйн хөтөч /ухуулагч/-ийн ажиллах журам”⁶, “Хууль зүйн салбарын үйл ажиллагаанд холбогдох мэдээ, мэдээлэл бэлтгэж, олон нийтэд хүргэх журам”⁷, “Эрх зүйн мэдээлэл бэлтгэх, түгээх аргачлал”⁸ зэрэг эрх зүйн баримт бичгийг тус тус батлан хэрэгжүүлж иржээ.

Гэсэн хэдий ч “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан⁹-д “Бүх нийтийн эрх зүйн сургалтын тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлсэн боловч үр дүн хангалттай бус байна. ...Хууль тогтоомжийг олон нийтэд тайлбарлан таниулах, сурталчлах ажил хангалттай бус байна” гэж дүгнэжээ. Түүнчлэн иргэд өөрт шаардлагатай эрх зүйн мэдээ, мэдээллийг хүссэн газраасаа, хүссэн цагтаа авах нөхцөл боломж бүрэн хангагдаагүй, иргэдэд хүрч буй мэдээлэл нь нэгдсэн тогтолцоогүй, арга зүйгүй байснаас гадна өмнө хэрэгжүүлсэн арга хэмжээг системтэй, тасралтгүй

¹ Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан

² Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2004 оны 45 дугаар тушаалаар батлагдсан

³ Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолоор батлагдсан

⁴ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 67 дугаар тушаалаар батлагдсан

⁵ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 67 дугаар тушаалаар батлагдсан

⁶ Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2011 оны 124 дүгээр тушаалаар батлагдсан

⁷ Хууль зүйн сайдын 2016 оны А/50 дугаар тушаалаар батлагдсан

⁸ 2016 онд Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга баталсан

⁹ Монгол улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ. Тайлан. 2008 он. 326-р тал

үргэлжлүүлж чадаагүй зэргээс хамааран иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсрол, соёлыг дээшлүүлэх ажил хүссэн үр дүндээ хүрэхгүй байна.

Монгол Улсад амьдарч буй иргэдийн өдөр тутмын амьдралд тулгарч буй хууль эрх зүйн мэдлэгтэй холбоотой үүсч байгаа бэрхшээл, түүнийг шийдвэрлэж буй арга зам, нөхцөл байдлыг сүүлийн 3 жилийн байдлаар судлахад¹⁰ иргэдийн 54,8% нь хууль эрх зүйн үр дагавар бүхий ямар нэг бэрхшээл тохиолдсон бөгөөд тэдний 50,5% нь түүнийг шийдвэрлэх ямар нэг оролдлого хийгээгүй байна. Хууль зүйн туслалцаа аваагүй иргэдийн 36,8% нь юу ч хийгээд нэмэргүй гэж бодсон, 25,5% нь юу хийхээ мэдэхгүй байсан, 17,3% нь тийм ноцтой асуудал биш гэж үзсэн, 15,7% нь надад ямар эрх байгааг мэдээгүй гэж хариулсан байна. Харин хууль зүйн туслалцаа авсан иргэдийн 40,8% нь найз нөхөд, хамаатан садан, танил талдаа хандсан, 14,5% нь холбогдох төрийн байгууллагад хандсан, 15,6% нь цагдаагийн байгууллагад хандсан, 14,5% нь хуульч, өмгөөлөгчид хандсан байна. Судалгаанд хамрагдсан 1630 иргэнээс өөрт нь тодорхой бэрхшээл тохиолдсоноос үл хамааран “Хэрэв ямар нэг бэрхшээл тохиолдвол хаашаа хандахаа мэдэхүү?” гэж асуухад 57,1% нь “Мэдэхгүй” гэж хариулжээ.

Дээрх судалгааны дүнгээс үзэхэд иргэд хуулиар олгогдсон боломжоо ашиглан зөрчигдсэн эрхээ сэргээлгэх, аюулгүй байдлаа хамгаалах явдал хангалтгүй байгаа нь тогтоогдож байна. Энэ нь иргэдийн эрх зүйн боловсрол дутмаг, өөрт тулгарсан асуудлаа хуулийн аргаар шийдэх чадавхи сул байгаатай холбоотой бөгөөд улмаар хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалж чадахгүй хохирох нөхцлийг үүсгэж байна.

Хүний эрхийг хангах, эрх зүй, шударга ёсны хүртээмжийг дээшлүүлэх зорилтууд олон улсын болон үндэсний хэмжээний бодлогын баримт бичгүүдэд цөөнгүй тусгагдсан байдаг. Тухайлбал, НҮБ-ийн гишүүн 193 орны хамтын шийдвэрээр 2015 онд батлагдсан Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилтын 16-д “Тогтвортой хөгжлийн төлөөх тайван, бүгдийг хамарсан нийгмийг дэмжих, шударга ёсыг бүгдэд хүртээмжтэй болгох, бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, бүгдийг хамарсан тогтолцоог бий болгох”, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”¹¹-д “ядуурлын бүх төрлийг эцэс болгоно, хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий 70 орны нэг болно, хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвшсөн байна” гэсэн зорилтуудыг тодорхойлсон. Дээрх зорилтуудыг хангах нэг чухал алхам нь эрх зүйн мэдээллийн тогтолцоог сайжруулж, иргэдийн эрх зүйн мэдлэг, чадавхийг дээшлүүлэх замаар шударга ёс, хууль ёсыг бэхжүүлэх явдал юм. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Засаглалын бодлого, Шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоог боловсронгуй болгож, хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд “5.3.7.Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж заасан.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагад тулгуурлан “Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр”-ийг “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”¹², “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”¹³-д нийцүүлэн боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1.Иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх

¹⁰ Иргэдийн эрх зүйн чадавхийн өнөөгийн байдалд хийсэн судалгаа. Нээлттэй нийгэм форум.2016 он.

¹¹ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан

¹² 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан

¹³ Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан

замаар бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Энэхүү хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1.бүх нийтийн эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг боловсронгуй болгоно.

2.2.2.бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлж, тогтсон сувгуудыг бий болгон, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ.

2.2.3.иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд бүх талын идэвхтэй оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулна.

2.3.Хөтөлбөрийг 2018-2023 онд 5 жилийн хугацаанд 2 үе шаттай хэрэгжүүлэх бөгөөд 1 дүгээр үе шат /2018-2020 он/-нд бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг, 2 дугаар үе шат /2021-2023 он/-нд эхний шатны үйл ажиллагаанд үнэлгээ хийж, бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

3.1. Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1.**Хүний эрхэд суурилсан, жендерийн мэдрэмжтэй байж, соёлыг хүндэтгэх:** Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүний эрхийг дээдэлж, жендерийн тэгш байдлыг ханган, соёлын уламжлал, шинэчлэлийг хүндэтгэнэ.

3.1.2.**Ил тод, нээлттэй байх:** Иргэд эрх зүйн боловсролоо дээшлүүлэх бүхий л арга хэлбэр нь нээлттэй, ойлгомжтой байна.

3.1.3.**Хүртээмжтэй, тасралтгүй байх:** Хууль зүйн үйлчилгээ, мэдээлэл нь иргэд хаана, ямар нөхцөлд амьдарч байгаагаас үл хамааран хүн бүрт хүртээмжтэй, тасралтгүй хүрч байна.

3.1.4.**Хамтын ажиллагаа уялдаа холбоотой байх:** Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаа нь төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлд суурилна

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1."Бүх нийтийн эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг боловсронгуй болгоно." гэсэн хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.1.1.эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны агуулгыг бэлтгэх, түгээх нэгдсэн арга зүйтэй болох;

4.1.2.иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан, зорилтот бүлэгт тухайлбал харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэн, өндөр настанд ээлтэй, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон эрх зүйн боловсролын агуулгыг боловсруулах;

4.1.3.бүх нийтийн эрх зүйн боловсролын агуулгыг иргэдийн нийтлэг болон тусгайлсан хэрэгцээг хангахуйц байхаар боловсруулах;

4.1.4.хууль, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон акт, хуулиар эрх

олгосон этгээдийн гаргасан эрх зүйн үр дагавар бүхий шийдвэрийг бүрнээр нь болон хэсэгчлэн ангилсан байдлаар иргэдэд хүргэх **эрх зүйн мэдээллийн** хүртээмжийг нэмэгдүүлэх;

4.1.5.хууль тогтоомжийг бүхэлд нь болон тодорхой нэг хууль, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон захиргааны акт, хуулиар эрх олгосон этгээдийн гаргасан эрх зүйн үр дагавар бүхий шийдвэр, тэдгээрийн тодорхой заалтыг олон нийтэд энгийн, ойлгомжтой хэлбэрээр тайлбарлан таниулах **эрх зүйн сурталчилгааг** тогтмол хийх;

4.1.6.иргэдэд эрх зүйн мэдлэг түгээх, тэдний чадварыг хөгжүүлэх, эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадвар эзэмшүүлэх **эрх зүйн шаталсан сургалт** явуулах;

4.1.7. хууль зүйн туслалцааны 2 шатлалтай үйлчилгээг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, эрх зүйн анхан шатны зөвөлгөө өгөх, зорилтот бүлэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх **эрх зүйн туслалцааны чанар**, хүртээмжийг сайжруулах;

4.1.8.хууль зүйн анхан шатны үйлчилгээний бодит хэрэгцээ шаардлагыг тогтоож, шийдвэрлэх бодлогын шийдлийг тодорхойлоход туслах **эрх зүйн судалгаа хийж**, үр дүнг тооцдог болох;

4.2."Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлж, тогтсон сувгуудыг бий болгон, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ." гэсэн хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.2.1.эрх зүйн хөтөчийн тогтолцоо бий болгох;

4.2.2.эрх зүйн хөтөчийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх;

4.2.3.эрх зүйн мэдээлэл, сургалт сурталчилгаа, судалгаанд мэдээллийн технологийг ашиглах;

4.2.4.эрх зүйн мэдээллийн цахим нэгдсэн сан legalinfo.mn-ийн хүртээмжийг нэмэгдүүлэн хөгжүүлэлт хийх;

4.2.5.хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдэд эрх зүйн мэдээлэл, зөвлөлгөө, туслалцаа үзүүлэх хүний нөөц /дохионы хэлний хэлмэрч, сэтгэл зүйч/-ийг бэлтгэх;

4.2.6.төрийн болон төрийн бус байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд мэргэшсэн эрх зүйн хөтөч ажиллуулах;

4.3."Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд бүх талын идэвхтэй оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулна." гэсэн хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

4.3.1.эрх зүйн сургалт, сурталчилгаанд орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон Хууль зүйн туслалцааны төвийн орон нутаг дахь салбарын оролцоог нэмэгдүүлэх;

4.3.2.хуулийн сургуулиуд болон төрийн бус байгууллагуудын дэргэдэх хуулийн клиник төвийн иргэдэд эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг тогтмолжуулах, чадавхижуулах үйл ажиллагааг бүх талаар дэмжих;

4.3.3.эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгааны ажилд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангах;

4.3.4.иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хууль ёсыг дээдлэх хандлага, дадлыг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг байнга зохион байгуулах;

4.3.5.хэвлэл, мэдээллийн байгууллага, гар утасны оператор компани болон бусад хувийн хэвшлийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд нийгмийн

хариуцлагын хүрээнд эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны ажилд оролцохыг бүх талаар дэмжих;

4.3.6.тодорхой түвшний эрх зүйн мэдлэг эзэмшсэн хамт олон болж, үүнийгээ үнэлүүлэн баталгаажуулахад чиглэсэн санал, санаачилга өрнүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

4.3.7.бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжигч байгууллага, хамт олныг сурталчлах, алдаршуулах үйл ажиллагааг зохион байгуулах;

4.3.8.нийгмийн сүлжээ болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэдэд сөрөг, буруу ташаа эрх зүйн мэдлэг олгох агуулга бүхий мэдээлэл, контентыг нийтэд түгээхэд хязгаарлалт хийх.

Тав. Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

5.1.Хөтөлбөрийн нийгэмд үзүүлэх үр нөлөө:

5.1.1.иргэд хаана, ямар нөхцөлд амьдарч байгаагаас үл хамааран хууль зүйн үйлчилгээ, мэдээллийг авах нөхцөл бүрдэнэ.

5.1.2.иргэд өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо хуулийн хүрээнд хамгаалах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх чадвар, боломж нэмэгдэнэ.

5.1.3.төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо нэмэгдэж, иргэний ашиг сонирхол зөрчигдөж байгаа болон төрийн байгууллагаас гарах аливаа шийдвэр нь хууль ёсны эрх, ашиг сонирхолтой зөрчилдөнө гэж үзсэн тохиолдолд үзэл бодол байр сууриа илэрхийлэх чадвар нэмэгдэнэ.

5.1.4.бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, иргэний оролцоо, дэмжлэг сайжирна.

5.1.4.хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх иргэдийн эрх зүйн ухамсар дээшилнэ.

5.2.Хөтөлбөрийн эдийн засгийн үр нөлөө:

5.2.1.иргэд эрхээ эдлэх, баталгаажуулах, амьжиргаагаа дээшлүүлэх чадвар, боломж бололцоо нэмэгдэнэ.

5.2.2.иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалах, зөрчигдсөн эрхээ сэргээх иргэдийн чадвар нэмэгдсэнээр бусдын буруутай үйл ажиллагаанаас учрах эдийн засгийн хохирол буурна.

5.2.3.иргэдийн эрх зүйн боловсрол дээшилснээр хууль зүйн мэдээлэл, туслалцаа авахад хялбар болж, үр ашиггүй илүү зардал гаргахгүйгээр авч чаддаг болно.

5.2.4.эрх зүйн мэдээлэл, хууль зүйн туслалцаа үзүүлэх цахим сүлжээг нэвтрүүлснээр хууль зүйн мэдээлэл, туслалцааны бодит зардал буурна.

5.2.5.хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх иргэдийн ухамсар дээшилснээр гэмт хэрэг, зөрчил буурна.

5.3.Хөтөлбөрийн 3 зорилтын хүрээнд үйл ажиллагааны 20 чиглэлээр 99 арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.4.Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

5.4.1.хөтөлбөрийн хэрэгжилтийг үр нөлөөний болон хүрсэн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд иргэдийн эрх зүйн чадавхийн өнөөгийн байдалд хийсэн судалгааг суурь үзүүлэлт болгон ашиглана:

	Хөтөлбөрийн зорилго, зорилт	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин		
			Суурь үзүүлэлт 2016 он	2020 он	2022
Үр нөлөөний шалгуур үзүүлэлт					
Зорилго	Иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх замаар бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.	Хууль зүйн үр дагавар бүхий бэрхшээлээ шийдэх оролдлого хийгээгүй иргэдийн эзлэх хувь	50,5	40	20
		Өөрт тулгарсан бэрхшээлтэй холбоотой мэдээлэл авахаар төрийн байгууллага албан тушаалтанд хандсан иргэдийн эзлэх хувь	21,9	10	0
		Өөрт тулгарсан бэрхшээлтэй холбоотой мэдээлэл авахаар төрийн байгууллага албан тушаалтанд хандсан боловч мэдээлэл авч чадаагүй иргэдийн эзлэх хувь	16,3	10	0
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт					
Зорилт1	Бүх нийтийн эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг боловсронгуй болгох;	Сургалтын /танхимын, зайн/ агуулга хөтөлбөр боловсруулах нэгдсэн арга зүйтэй болсон байна.	-	Сургалтын агуулга, хөтөлбөрүүдийг батлагдсан арга зүйн дагуу боловсруулдаг болсон байна.	Сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсронгуй болгоно
		Сургалтанд хамрагдсан хүний тоо /бүлэг тус бүрээр/-г гаргаж, үнэлгээ, дүгнэлт хийсэн байдал.	-	Сургалт бүрийн үр дүнг тооцсон байна.	Эрх зүйн мэдээлэл тэгш хүрдэг, үнэлгээний үр дүнгээр сургалтын агуулгыг сайжруулдаг болсон байна.
		Сургалт, сурталчилгааны гарын авлага, хэлбэр нь нийт иргэдэд хүртээмжтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, зорилтот	-	Эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа нь нийгмийн бүх бүлгүүдэд хүртээмжтэй болсон байна	Нийт хүн амын 30-аас доошгүй, зорилтот бүлгийн 80-аас доошгүй хувьд хүрсэн байна.

		бүлгүүдэд ээлтэй байна.			
Зорилт2	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлж, тогтсон сувгуудыг бий болгон, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ	Эрх зүйн хөтөчийн тоо	-	500 эрх зүйн хөтөч	1000 эрх зүйн хөтөч
		Эрх зүйн цахим хөтөч ажилладаг болсон байна	-	e-hutuch.mn портал сайт ажилладаг болсон байна	e-hutuch.mn портал сайтын хөгжүүлэлт хийнэ
		Хууль зүйн туслалцаа авсан иргэдийн тоо ¹⁴	2015 - 8363 2016 - 6631 2017- 4048 ¹⁵	Жилд 9500 аас доошгүй	Жилд 11500 аас доошгүй
		Эрх зүйн хэрэгцээ шаардлагын судалгааны үр дүнд түүнийг хууль зүйн хувьд шийдвэрлэх бодлогын хувилбар тодорхойлсон, мэдээллийн агуулгыг сайжруулсан байдал	-	Хэрэгцээ шаардлагын судалгааг жил бүр хийсэн байна	Хэрэгцээ шаардлагын судалгаа жил бүр хийсэн, судалгааны үр дүнгээр мэдээллийн агуулгыг сайжруулах ажил жил бүр хийгдсэн байна.
Зорилт3	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд бүх талын идэвхитэй оролцоог хангаж, тэдний үйл ажиллагааг уялдуулна.	Мэргэшсэн эрх зүйн хөтөчтэй байгууллагын тоо	-	50	120
		Эрх зүйн тогтмол нэвтрүүлэг, булан ажиллуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагын тоо	Хандалт ихтэй 8 сайт, хамгийн их борлуулагттай 10 сонин, ТВ-ийн 19 нэвтрүүлэг	Нэвтрүүлэг болон бусад хэвлэлийн мэдээллийн агуулгыг сайжруулж, тогтмол гардаг болсон байна.	Дугаар алгасахгүй, 7 хоногт 2 удаа тогтмол цагтай болж, нэвтрүүлгийн тоог нэмэгдүүлнэ
		Хууль зүйн клиник төвүүдтэй хуулийн сургууль, төрийн бус байгууллагын тоо	-	Байнга, идэвхитэй ажилладаг клиник төв 10 аас доогүй байна.	Байнга, идэвхитэй ажилладаг клиник төвийн тоо болон үйлчлүүлэгчийн тоо өссөн байна.

¹⁴ Хууль зүйн туслалцааны төвөөс 2015, 2016, 2017 онд иргэдэд үзүүлсэн хууль зүйн зөвлөгөөний тоо

¹⁵ 2017 оны эхний хагас жилийн байдлаар

Зургаа.Хөтөлбөрийн санхүүжилт, шаардагдах хөрөнгийн хэмжээ

6.1.Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

6.1.1.улс, орон нутгийн төсөв;

6.1.2.гадаад улс, олон улсын байгууллагын хандив, тусламж;

6.1.3.төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, хөрөнгө;

6.1.4.хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

6.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд **нийт 11,257.7 сая** төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэсэн урьдчилсан тооцоололтой байна.

Долоо. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо, гүйцэтгэх чиг үүрэг

7.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангана.

7.2.Эрх зүйн боловсролын агуулгын нэгдсэн байдал, салбар дундын уялдаа холбоог хангах, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих чиг үүрэг бүхий бүх нийтийн эрх зүйн боловсролын орон тооны бус Үндэсний зөвлөл ажиллана. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд хууль зүй, боловсрол, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбар, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл оролцсон байна.

7.3.Үндэсний зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэн гүйцэтгэнэ.

7.4.Үндэсний зөвлөл нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

7.4.1.хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад салбар дундын уялдаа холбоог зохицуулах, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, түүний зарцуулалтад хяналт тавих;

7.4.2.эрх зүйн сурталчилгаа, сургалт, судалгааны агуулга, чиглэлийг баталгаажуулах;

7.4.3.тухайн жилийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэлэлцэн баталж, хэрэгжилтийг зохион байгуулах;

7.4.4.хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэн дүгнэж, Засгийн газарт танилцуулах;

7.5.Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад төрийн байгууллагууд дараах чиг үүрэгтэй оролцоно:

7.5.1.хариуцсан салбарын хүрээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

7.5.2.хариуцсан салбарын хууль, эрх зүйн актуудыг олон нийтэд таниулахад чиглэгдсэн сургалт, сурталчилгааны материалыг нэгдсэн /батлагдсан арга зүйн дагуу бэлтгэж, хүргэх арга хэмжээ авах;

7.5.3.хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг Үндэсний зөвлөлд тайлагнах.

7.6.Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяа хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага /Хууль зүйн үндэсний хүрээлэн/ дараах чиг үүрэгтэй оролцоно:

7.6.1.эрх зүйн мэдээллийн цахим нэгдсэн сан legalinfo.mn, эрх зүйн цахим хөтөч e-hutuch.mn -ийг эрхлэн хөтлөх;

7.6.2.эрх зүйн сургалт, сурталчилгааны агуулга бэлтгэх, түгээх арга зүйг боловсруулж, батлуулах;

7.6.3.эрх зүйн хөтөч бэлтгэх;

7.6.4.иргэдэд зориулсан эрх зүйн анхан шатны сургалтын хөтөлбөр боловсруулан, батлуулах;

7.6.5.бүх шатны боловсролын байгууллагаар дамжуулан хүүхэд, залуучуудад эрх зүйн боловсрол олгох, эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

7.6.6.бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай судалгаа хийх;

7.8.Бүх шатны засаг дарга, төрийн байгууллага жил бүр хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах ба хөтөлбөрт тодорхой хугацаанд, тогтмол зохион байгуулагдахаар тусгагдсан арга хэмжээг оролцогч талуудын үйл ажиллагаагаатай уялдуулан хамтран төлөвлөнө.

7.9.Бүх шатны засаг дарга, төрийн байгууллагууд эрхэлсэн асуудлын хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн мэдээлэл бэлтгэх, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд оруулах, эрх зүйн хөтөчийн үүрэг гүйцэтгэх ажилтантай болж, тогтвор суурьшилтай ажиллуулна.

7.10.Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд өөрсдийн мэргэшсэн чиглэлээр эрх зүйн сургалт, сурталчилгаа хийх, судалгаанд оролцох, өөрийн байгууллагын ажилтан, албан хаагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

Найм.Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, хяналт-шинжилгээ,үнэлгээ хийх

8.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд хөтөлбөрийн хэрэгжилтийн тухайн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 01-ний дотор Үндэсний зөвлөлийн ажлын албанд хүргүүлнэ.

8.2.Үндэсний зөвлөлийн ажлын алба тайланг нэгтгэн, 2 дугаар сарын 10-ны дотор Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

8.3.Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” –ын дагуу хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

8.4.Шаардлагатай тохиолдолд Үндэсний зөвлөлийн саналаар /шийдвэрээр/ хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 18 сараас доошгүй хугацааны дараа “Үр дүнд суурилсан явцын үнэлгээ”, “Хөндлөнгийн үнэлгээ” хийлгэж болно.

8.5.Хөтөлбөрийн 1, 2 дугаар үе шат хэрэгжиж дуусах хугацаанаас 6 сарын өмнө “Үр дүнд суурилсан эцсийн үнэлгээ” хийлгэж, тайланг Үндэсний зөвлөлөөр хэлэлцэн, үр дүнг Засгийн газарт танилцуулна.

-----000-----